



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 31 өдөр

Дугаар Б/24

Хэрлэн сум

Аймгийн ерөнхий архитекторыг
улируулан томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хот байгуулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.1.2, Засгийн газрын 2019 оны 09 дүгээр тогтоолын 1.1, 2.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хот байгуулалтын тухай хуульд заасан шаардлага хангасан Шүрхүүгийн Ариунболорыг аймгийн Ерөнхий архитектороор түр томилсугай.

2. Аймгийн Ерөнхий архитектор Ш.Ариунболорт ажил үүргийг хавсран гүйцэтгэсэн нэмэгдэлийг ТЗ-9 дүгээр шатлалаар үндсэн цалингийн 40 хувиар цалинжуулахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Сүнгээ)-д зөвшөөрсүгэй.

3. Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд “Аймаг, хотын Ерөнхий архитекторын дүрэм”-ийг баримтлан хот төлөвлөлтийн бодлогийг хэрэгжүүлж, мэдээллийн бааз үүсгэн ажиллахыг аймгийн Ерөнхий архитектор (Ш.Ариунболор)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Э.Мөнх-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ